

ОЛОН УЛСЫН ГРАУНД ГОЛЬФИЙН ТЭМЦЭЭН ЮРИХАМА 2026

Тэмцээний удирдамж

(2027 Кансай Граунд Гольфийн Дэлхийн Мастеруудын Наадмыг угтсан
тэмцээн)

2026 Yurihama International Ground Golf Open

1. Зорилго

Олон улсын Граунд Гольфийн тэмцээнийг зохион байгуулах зорилго нь бага балчираас ахмад настан хүртэл аль ч насны хүмүүс тоглох боломжтой, Тоттори мужийн Юрихама сумаас гаралтай Граунд Гольфийн спортыг дэлгэрүүлэн хөгжүүлж, тоглогчидын хил дамнасан харилцааг хөгжүүлэхэд оршино. Тус тэмцээн явагдах талбайд “World Masters Games 2027 Кансай” олон улсын спортын наадмын Граунд Гольфийн төрөл зохиогдох юм.

2. Зохион байгуулагч

Олон улсын Граунд Гольфийн тэмцээнийг зохион байгуулах хороо

3. Хамтран зохион байгуулагч

Тоттори мужийн захиргаа, Юрихама сумын захиргаа

4. Хянах байгууллага

Юрихама сумын Граунд Гольфийн холбоо

5. Дэмжигч байгууллага (урьдчилсан байдлаар)

Олон Улсын Граунд Гольфийн Холбоо, Нийтийн ашгийн төлөөх хуулийн этгээд Японы Граунд Гольфийн Нийгэмлэг, Тоттори мужийн Граунд Гольфийн Нийгэмлэг, Тоттори мужийн Боловсролын хороо, Нийтийн ашгийн төлөөх хуулийн этгээд Тоттори Мужийн Олон Улсын Харилцааны Сан, Шин Нихонкай сонины компани, NHK Тоттори телевиз, Хавай халуун рашаан Того халуун рашаант зочид буудлын хоршоолол, Юрихама сумын Боловсролын хороо, Юрихама сумын Олон Улсын Харилцааны Нийгэмлэг, Юрихама сумын Биеийн Тамирын Нийгэмлэг, Юрихама сумын Спорт Хөгжлийн Хорооны Зөвлөл, ASICS JAPAN ХК

6. Ивээн тэтгэгч (урьдчилсан байдлаар)

CHUBU ХК

7. Хугацаа

2026 оны 5-р сарын 30 (Бямба), 31 (Ням)-ний өдөр

※Бороотой цаг агаартай байсан ч тэмцээн явагдана

8. Газар

Тоттори муж Тохаку тойргийн Юрихама сум 1313

Граунд гольфийн Фүрүсато цэцэрлэг – Шиоказэно Ока Томари

9. Хөтөлбөр:

1 дэх өдөр: 5-р сарын 30-ны өдөр (Бя) Бүртгэл 08:20 – 08:50

Нээлтийн ажиллагаа 09:00 – 09:40

Албан ёсны тэмцээн 10:30 – 15:30

(1 дэх өдрийн албан ёсны тэмцээн явагдаж дууссаны дараа, оролцогч улсуудын төлөөлөгчдийн санал солилцох уулзалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна)

2 дахь өдөр: 5-р сарын 31-ний өдөр (Ня) Бүртгэл 09:00 – 09:30

Нөхөрсөг тэмцээн 10:00 – 11:40

Өдрийн хоол 11:40 – 12:20

Шагнал гардуулах ёслол,

хаалтын ажиллагаа 12:30 -13:00

Сугалаа 13:00 – 13:30

10. Оролцох хүний тоо 384 оролцогч

(※Тогтоосон тооноос илүү гарсан тохиолдолд оролцогчдыг сугалаагаар оноож шийдвэрлэнэ.)

11. Тэмцээнд оролцох төлбөр: 1 хүн 3,000 иен (2 өдрийн үдийн хоол (бэнто буюу бэлдсэн хоол) орно). ※Төлбөрийг тэмцээн явагдах өдөр бүртгэл хийлгэхдээ бэлнээр төлнө үү.

12. Тоглолтын дүрэм: Нийтийн ашгийн төлөөх хуулийн этгээд Японы Граунд Гольфийн Нийгэмлэгийн дүрмээр явагдана.

13. Тоглох аргачлал:

★ 1 дэх өдөр (албан ёсны тэмцээн) 5-р сарын 30-ны өдөр (Бя): 8 үүрээр 3 тойрог цохиж, цохилтын оноогоор насны ангилал (доорх хүснэгтийг харна уу)-аар байр эзлүүлнэ.

Насны ангилал

Хүйс	Төрөл	
Эр	Граунд Гольф	~39, 40~49, 50~59, 60~64, 65~69, 70~74, 75~79, 80~
Эм	Граунд Гольф	~39, 40~49, 50~59, 60~64, 65~69, 70~74, 75~79, 80~

※ 2026 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар тооцож насны ангилалд хамруулна.

★ 2 дахь өдөр (нөхөрсөг тэмцээн) 5-р сарын 31-ний өдөр (Ня): 8 үүрээр 1 тойрог цохиж, нийт цохилтын оноогоор баг тус бүрээс 1 дүгээр байрыг тодруулна.

14. Шагнал

- ① 1 дэх өдөр (албан ёсны тэмцээн) :
Эрэгтэй эмэгтэй оролцогч тус бүр 8 насны ангилалаар: 1 – 3 байр өргөмжлөл, дурсгалын зүйл
- ② 2 дахь өдөр (нөхөрсөг тэмцээн) : Баг тус бүрээс 1 дүгээр байрыг шалгаруулж дурсгалын зүйл
- ③ Нэг цохиотоор бөмбөг оруулсан шагнал
- ④ Тусгай шагнал : (Гадаадын болон дотоодын эрэгтэй эмэгтэй оролцогч тус бүрийн хамгийн өндөр настай оролцогч, хамгийн залуу оролцогч, хамгийн холоос оролцогч)

15. Тэмцээнд бүртгүүлэх арга

Бүртгэлийн хуудас дээр шаардлагатай мэдээллүүдийг бөглөж, заасан хугацаанаас өмнө ирүүлнэ үү.

[Бүртгүүлэх, холбоо барих хаяг]

682-0723 Tottori-ken, Tohaku-gun, Yurihama-cho, Hisadome 19-1

Олон улсын граунд гольфийн тэмцээнийг зохион байгуулах хороо

E-mail : groundgolf@yurihama.jp

TEL: 0858—35—5368 FAX: 0858—35—3697

Албан ёсны вэб сайт: <https://www.yurihama.jp>

16. Бүртгэлийн хугацаа: 2026 оны 3-р сарын 19-ны өдөр (Пүрэв) хүртэл

17. Бусад

- ① Нийтийн ашгийн төлөөх хуулийн этгээд Японы Граунд Гольфийн Нийгэмлэгээс батламжилсан цохиур, бөмбөгийг хэрэглэнэ. Батламжилсан хэрэгслээс өөр цохиур, бөмбөг хэрэглэсэн тохиолдолд үүссэн осол гэмтлийг хэрэглэгчийн өөрийн хариуцлагад тооцох ба зохион байгуулагч тал хариуцлага хүлээхгүй болно.

※ Хэрэгсэл шаардлагатай хүнд зохион байгуулагч тал хэрэгслийг үнэгүй зээлүүлж хэрэглүүлнэ.

- ② Оролцогч өөрөө тэмдгээ авч ирнэ. Оролцогчийн шагнал болгож тараасан тэмдгийг хэрэглэж болно.

- ③ Оролцогчид өөрсдөө даатгалд хамрагдана.
- ④ Тоглолтын үеэр осол гэмтэл гарсан тохиолдолд зөвхөн яаралтай тусламжийг л үзүүлнэ
- ⑤ Зохион байгуулагч үдийн хоолыг (бэнто) бэлдэнэ.
- ⑥ Цаг агаар муу тохиолдолд хөтөлбөрт өөрчлөлт орох тохиолдол байна.
- ⑦ Нийт оролцогчид оролцогчийн батламж гардуулна.
- ⑧ Тус удирдамжид зааснаас бусад нөхцөл байдал үүссэн тохиолдолд зохион байгуулагч тал асуудлыг шийдвэрлэнэ.
- ⑨ Оролцогчдын харилцааны арга хэмжээг 2026 оны 5-р сарын 29-ний өдөр (Баасан) 17:00 цагаас зохион байгуулна. (Газар: Сүймэйсо)
- ⑩ Японоос бусад оронд амьдардаг зөвхөн тамирчид болон оролцогчид л тус зохион байгуулах хороогоор дамжуулж Хавай, Того халуун рашаантай зочид буудалд байрлах тохиолдолд 1 хоногт 1 хүн тутамд 5,000 иений хөнгөлөлт үзүүлнэ. (Хавсралтаас харна уу.)